

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЯЛ ТЭНСЭХ ИНСТИТУЦИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛТ

HISTORICAL DEVELOPMENT OF BINDING OVER INSTITUTION IN THE CRIMINAL LAW OF MONGOLIA



А.БААСАНЦЭРЭН

ОХУ-ын ДЯЯ-ны Омскийн Академийн адъюнкт,
цагдаагийн дэд хурандаа

BAASANTSEREN A.

Adjunct, Academy of Omsk, Ministry of Internal Affairs,
Russia, Police Lieutenant Colonel

Товч агуулга: Ял тэнсэх институцийн анх олон улсад болон Орос зөвлөлтөөр дамжин манай улсад хэрэглэж ирсэн түүхэн уламжлал, Монгол улсын эрүүгийн эрх зүйн түүхэн эх сурвалж болох 1926 онд анхны шүүх цаазны бичиг, түүнээс хойшхи хуулиудад тусгагдаж хэрэгжүүлж байсан түүхэн хөгжлийг судалсан эрүүгийн эрх зүйн судалгааны өгүүлэл юм.

Abstract: Binding over Institution has been used in the Criminal Law of Mongolia through criminal Laws of foreign countries, particularly Russia and Soviet Union. The article focuses on studying the historical development of this institution reflected on first trial script (1926) and other legislations of the country.

Өнөөдөр дэлхийн ихэнхи улс орны эрүүгийн эрх зүйн ялын бодлогод хорих ялаас аль болох татгалзах, бусад төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсон байна.

Манай улс сүүлийн жилүүдэд хорих ялыг биеээр эдлүүлэх явдал жил ирэх тутам багасаж байна, үүний нэг жишээ бол 2010 онд шүүхээс хорих ял оногдуулсан 7292 ялтны 2444 буюу 33,6%, 2011 онд 8210 ялтны 3084 буюу 37,5%, 2012 онд 8324 ялтны 3217 буюу 38,6%, 2013 онд 8065 ялтны 3342, буюу 41,4%, 2014 онд 8178 ялтны 3396 41,5% хувьд нь оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан байна.

Ял тэнсэх институц нь 19 зууны 40-өөд оны үед Английн шүүгч Бирмингама Метью Хилл гэдэг хүн анх өвчтэй ялтануудад өвчнөө эмчлүүлэх боломж олгох үүднээс биеээр эдлэх хорих ялаас чөлөөлөх, хорих ялыг торгох ялаар солих саналыг анх тавьж байснаар, 1879-өөс 1887 оны хооронд английн шүүхийн практикт хэрэглэж ирсэн байна.¹

19 зууны 60-аад оноос Англиас салбарлан АНУ-ийн Массачузетсом мужийн шүүх хэрэглэсэн байна. 1899 он гэхэд Америкийн ихэнхи мужууд Миннесота,

¹ П.И.Люблинский. Журнал "Право и жизнь" Условное осуждение. г Москва 1924 г .С.5

Иллинойс, Род-Айленд, Вермонте, Нью-Джерси, Нью-Йорке мужуудад хэрэглэж ирсэн байна. 1911 оны эцэс гэхэд 41 мужуудад тархан хэрэглэж байсан бол 1920 он гэхэд Хойд-Америк, Англии, Шотланд, Канад, Австрали, Шинэ Зеланд, Өмнөд-америкийн орнуудад ял тэнсэх институцийг өргөн хэрэглэх болсон байна.²

19 зууны 60-аад оноос Англиас АНУ-д салбарласан бол Европт Бельги, Франц, Германаар дамжин Оросод орж ирсэн байна. 1894 онд Оросын эрдэмтэн А.А. Пионтковский анх “ял тэнсэж хянан харгалзах тогтолцоо” гэсэн анхны нийтлэл гаргасанаас хойш 1900 онд ял тэнсэх асуудлыг Оросын хууль цаазны бичигт урьдчилсан байдлаар нэмэлт оруулан хэрэглэж болохыг Төрийн зөвлөлөөс баталж өгсөн байна.

Оросын эрдэмтэн Н.И. Фалеева 1904 онд бичихдээ: Биднийцаг үед манайэрүүгийн тогтолцооны гажуудлыг засахтуршилтынбүтээгдэхүүн бол ял тэнсэх явдал юм. Хэрэв хууль сахиулахарга хэрэгсэл нь төгс бус байвал түүнийг зайлшгүй засаж сайжруулах шаардлагатайбайдаг. Ял тэнсэх нь ялын бие даасан төрөл болсоноор орчин үеийн хорих ялын дутагдалтай талыг арилгах явдал юм.³

1907 оны 1 дүгээр сарын 21 нд хуулийн төсөл боловсруулах тусгай комисс байгуулсан байна, Энэ комисс нь 1-рт Ял тэнсэх институцийн хуулийн төсөл боловсруулах, 2-рт Шүүхийн шинэчлэлийн асуудал зэргийг боловсруулж 1909 оны 10 дугаар сараас 11-р сарын хооронд Бүх Оросын Төрийн Думаар батлуулсан байна.

Оросод 19 зууны сүүлч 20 зууны эхэн үеээс шинжлэх ухааны түвшинд судалж ирсэн.Тухайн үед ял тэнсэх институцийг тусгайлан судалж байсан судлаачид бол А.А. Пионтковский, Н.И.Фалеева, Н.С.Таганцев, И.П. Люблинский нар болох Оросын эрүүгийн эрх зүй тэр тусмаа ял тэнсэх институцийг судласан томоохон төлөөлөгчид юм.

Манай оронд 1921 онд ардын хувьсгал ялж улмаар 1924 онд Бүгд найрамдах засаглалыг тунхаглаж анхдугаар үндсэн хууль батлагдсанаас хойш хууль эрх зүйн томоохон өөрчлөлт шинэчлэлт хийгдсэний нэг илрэл бол 1926 онд анхны Шүүх цаазны бичгийг гаргасан байна. Энэ хуулийн 8 дугаар зүйлд Шүүх гэмт этгээдэд оногдуулсан ялаа биечлэн эдлүүлэхийг түдгэлзэн тэнсэж, гурваас таван жил хүртэл хугацаагаар хянан харгалзах бөгөөд уг хянан харгалзсан хугацаанд шийтгүүлсэн этгээд түрүүчийн үйлдсэн хэргийн нэг төрлийн гэмт хэрэг үйлдээгүй бол ялыг эдлүүлэхгүй тухай заасан байдаг. Гэвч энэ хуульд чухам ямар ялыг тэнсэж болохыг тодорхойлоогүйнь гадна хянан харгалзах хугацаанд түрүүчийн үйлдсэн хэргээс өөр төрлийн хэрэг үйлдсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх асуудлыг тодруулан заагаагүй нь дутагдалтай байсан байна.⁴

1929 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичиг-т Оноосон ялыг түдгэлзүүлэх нь шүүн таслах газраас тогтоосон нэг жилээс таван жил хүртэлх тэнсэх хугацааны дотор ялт хүмүүн дахин нэг төрлийн буюу өөр хүнд гэмт явдал эс үйлдвээс оноосон ялыг үл эдлүүлмой. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн хүмүүн зан авир нь ард олны дунд аюултай бол тэнсэж болохгүй гэж хуульчилсан байна.⁵ Энэ хуулийг өмнөх хуультай харьцуулбал шинэлэг зүйлүүд олон тусгагдсан. Тухайлбал Гэм буруутай этгээдийн ялыг тэнсэх хугацааг 1-5 жилийн хугацаатай байхаар хуульчилсан нь одоо хүртэл

² П.И.Люблинский. Дурдсан зохиол. Москва.,1924., 6 дахь тал.

³ Н.И. Фалеева Условное осуждение (новая область его применения) г Москва 1904 г С.43.

⁴ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2014, 307 дахь тал.

⁵ Д. Адъяабазар. Монгол улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ ., 1998, 39 дэх тал.

мөрдөгдөж ирсэн. Түүнчлэн 12-р зүйлийн тайлбарт хэрэг үйлдсэн этгээдийн зан авир нь ард олны дунд аюултай бол ялыг тэнсэхгүй гэж хуульчилсан байна, үүнийг дан ганц субъектив шинжээр нь буюу субъектын зан төлвөөр тогтоож байсан нь учир дутагдалтай байсан. Уг хуульд ял тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацааны дотор дахин гэмт хэрэг үйлдэхэд түрүүчийн тогтоолоор шийтгүүлсэн ялыг ямар журмаар эдлүүлэх асуудал тодорхойлоогүй юм. Дээрхи хуулиудад ял тэнсэх институци нь ялын бие даасан нэг төрөл болж хэрэглэгдэж байсан байна.

1934 оны Шүүх цаазын бичигт энэ хуулийн 6-р бүлгийн 38-д шийтгэсэн ялыг гүйцэтгэхийг түдгэлзэн, ялыг тэнсэх, хугацааны өмнө тэнсэж суллах гэж заасан байна. Шүүн таслах газар уг хэргийг хянаж үзээд олон нийтэд аюултай эсэхийг үзэж заавал хорих буюу хорихгүй албадан ажил хийлгэх зэрэг ялыг тэнсэх эрхтэй болно. Шүүн таслах газараас тогтоосон хянан харгалзах хугацаа нь 1 жилээс 5 жил хүртэл байна. Энэ хуулинд нь өмнөх хуулиудаас хэд хэдэн өөрчлөлт орсон байна.

Үүнд: 1. Тэнсэх явдлыг хорих, албадан ажил хийлгэх хоёр үндсэн ялын аль нэгэнд хэрэглэж байх.

2. Ял тэнсэх тохиолдолд тэнсэж байгаа үндсэн ял дээр хөрөнгө хураах буюу торгох нэмэгдэл ял оногдуулсан бол тогтоолд зааснаар гүйцэтгэж байх.

3. Ял тэнсэх үндэслэлийг хэргийн нийгмийн хор аюулын байдлаар тогтоосон.

Ял тэнсэх асуудлыг эрүүгийн ял шийтгэлийн нэг хэлбэр болгон заадаг байсныг хассан байна.

1940 оны 6 сард хуралдсан Улсын 8 их хурал шинэ Үндсэн хуулийг батлан гаргасантай холбоотойгоор Монгол улсад дагаж мөрдөх хууль дүрмүүд шинэчлэн боловсруулах ажил явагдаж үүний үр дүнд 1942 оны 1 сарын 17 нд Улсын бага хурлаар анх удаа Эрүүгийн хууль нэртэйгээр батлагдан гарсан. Энэ хуулийн 6 бүлэгт Тэнсэн шийтгэх ба хугацаа дуусахын өмнө суллаж тэнсэх тухай гэж бие даасан бүлэг болгон хуульчилсан. 50 зүйлд Шүүн таслах газар бол уг хэргийн байдал, олон нийтэд хэр аюултай болохыг хянан үзэж заавал хорих буюу хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ял оногдуулах эсвэл ялыг тэнсэхээр тогтоох эрхтэй болно.⁶

Шүүн таслах газраас тэнсэн харгалзахаар зааж тогтоосон хугацаа нь нэг жилээс доошгүй 5 жилээс дээшгүй байна. Тайлбар: Хорих буюу засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх явдал дээр мөнгө буюу эд хөрөнгөөс хураах нэмэгдэл ял шийтгэсэн байвал таслан шийтгэх тогтоолд заасан ялыг эдлүүлэх буюу тэнсэхийг үл ялгаварлан шууд гүйцэтгэвэл зохино.⁷

1960-аад он бол монгол оронд социализм байгуулах суурийг тавьж байсан цаг үе юм. БНМАУ-ын АИХ-ын 2 чуулганаар баталсан шинэ Эрүүгийн хуулийг 1961 оны 4 сарын 1-ээс мөрдөж эхэлсэн. Энэ хуулийн 4 бүлгийн 83 зүйлд “Ял шийтгэх ба ялаас чөлөөлөх тухай ,ял тэнсэх”.

1. Хэргийн учир шалтгаан ба хэрэгтний хувийн байдлыг харгалзан хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэсэн ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл тухайн шалтгааныг тодорхойлон тэнсэхээр тогтоож хуульд заасан хугацаагаар хянан харгалзана.

2. Хянан харгалзах хугацааг 1-ээс 5 жил хүртэл тогтооно.

3. Тэнсэгдсэн этгээдээс хянан харгалзах хугацааны дотор шинэ гэмт хэрэг

⁶ Даваасамбуу. Б, Совд Г, Ахметшин Х. М, Владимиров В. А, Загородников Н. И, Криволапов Г. Г, Наумов А.В, Худяков Е. А, Уголовное право МНР общая часть Москва 1983 г, стр 48.

⁷ Д. Адъяабазар. Дурдсан зохиол. УБ., 1998, 77 дахь тал.

үйлдвэл энэ хуулийн 31.6-д заасныг баримтална.

4. Тэнсэгдсэн этгээдэд торгууль, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг хураахаар шүүхээс оногдуулсан бусад нэмэгдэл ялыг хэрэглэж болохгүй.

5. Олон нийтийн байгууллага буюу хамт ажиллаж байсан ажилчин, албан хаагчид, нэгдлийн гишүүдийн хамт олноос тэнсэхийг хүссэн өргөдөл хүсэлтийг үндэслэж хэргийн учир шалтгаан ба хэрэгтний хувийн байдлыг харгалзан түүнийг засан хүмүүжүүлэхийг дээрхи байгууллагууд буюу хамт олонд хариуцуулах журмаар тэнсэж болно⁸ гэжээ.

Уг хуулиар олон нийтийн байгууллага, хамт олон нь уг этгээдийг тэнсэхийг хүссэн хүсэлтийг шүүхэд гаргавал тэдэнд хариуцуулах журмыг шинээр оруулж өгсөн нь тухайн үеийн нийгмийн хөгжил, ард иргэдийн эрхийн ухамсар дээшилснийг харуулсан чухал заалт болсон байна.

1986 онд БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 40 зүйлд ял тэнсэх асуудлыг дор дурдсанаар өөрчлөн найруулсан юм. Хэрэв хэргийн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд оногдуулсан хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэсэн дүгнэлтэд шүүх хүрвэл энэ шалтгааныг таслан шийдвэрлэх тогтоолд заавал зааж уг ялыг тэнсэж 1-ээс 5 жил хүртэл хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно.

Тэнсэгдсэн ялтанд Цагдан сэргийлэх байгууллага, насанд хүрээгүй этгээдэд ЦСБ болон орон нутгийн АДХГЗ-ны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс хяналт тавина.

1995 оны 12 сарын 11-ний “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” хуулийн 4 бүлгийн 21-р зүйлд тэнсэгдсэн ялтныг хараа хяналтдаа байлгаж, ялтны хөдөлмөр эрхлэлт, засрал хүмүүжлийн байдлыг хариуцах үүргийг сум, дүүргийн засаг дарга нарт хариуцуулах, тэнсэгдсэн ялтныг хянан харгалзах талаар Цагдаагийн байгууллага ямар үүрэг хүлээхийг болон мөн 22-р зүйлд ял тэнсэхийг хүчингүй болгож ялыг биечлэн эдлүүлэх үндэслэл журмыг хуульчилсан байна.⁹

2002 оны эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйл. “Тэнсэх” 61.1. Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан тохиолдолд түүнд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж, нэгээс таван жилийн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно. Тэнсэгдсэн ялтан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй.

61.2. Энэ хуулийн 61.1-д заасан журмыг ялтай байгаа этгээдэд хэрэглэхгүй.

61.3. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

61.4. Тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина.

61.5. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.¹⁰

⁸ Мөн тэнд.

⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011. 665-666 дахь тал.

¹⁰ Эрүүгийн хэрэг. эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2013. 27-28 дахь тал.

Ял тэнсэх гэдэг нь шүүхээс хорих ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд ялаас чөлөөлөх бус ялыг түдгэлзүүлж буй нэг хэлбэр мөн. Хууль зүйн үр дагавар нь уг ял нь тэнсэгдсэн этгээд тодорхой хугацаанд ялтайд тооцогдохоор илэрнэ.